

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

ГАЗАР ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ. ТҮҮХ, СОЁЛ, АРХЕОЛОГИЙН ӨВИЙН ОРОН ЗАЙН
ӨГӨГДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

MNS : 2021

Албан хэвлэл

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР
2021 ОН

ӨМНӨХ ҮГ

Стандарт, Хэмжил Зүйн Газар (цаашид СХЗГ гэх) нь олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

Тус газар нь үндэсний стандарт боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг.

Энэхүү стандартыг Монгол Улсын Засгийн газраас Үндэсний орон зайн өгөгдлийн талаар баримталж буй үзэл баримтлал, хөтөлбөрийн хүрээнд орон зайн өгөгдлийг цахимжуулах нэгдсэн систем бүхий геопорталын орон зайн өгөгдөл бүрдүүлэлт, солилцоотой холбоотой стандартын орчныг бий болгоход зориулсан өгөгдлийн сангийн бүтэц, техникийн шаардлагыг энэхүү баримт бичигт тусган боловсруулав.

Стандарт боловсруулах ажлыг “Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх” сэдэвт төслийн хүрээнд стандарт боловсруулалтын багийн доктор Б.Баяртунгалаг, С.Амаржаргал, З.Нямбаяр, доктор Б.Сайнбуян, мэргэшсэн инженер Э.Алтанбагана нар хамтран гүйцэтгэв.

Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор Ч.Амартүвшин, Шинжлэх ухааны академийн Палеонтологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант Б.Майнбаяр нар редакц хийж, Монгол Улсын боловсролын их сургуулийн багш, доктор Ө.Амгалан шүүмжийг хийв.

Стандартыг боловсруулахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын хамт олон, Газрын харилцааны техникийн стандартчиллын хорооны гишүүд, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн гишүүд болон бусад үнэтэй санал, зөвлөгөө өгсөн мэргэжлийн байгууллагын хамт олонд талархал илэрхийлье.

Энэ стандартын төслийг ТХ-36/Газрын харилцааны техникийн стандартчиллын хорооны хурлаар хэлэлцэн зөвшилцсөн болно.

Уг стандартыг Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1:2006, MNS 1-2:2006–ийн дагуу хянаж, боловсруулав.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)
Энхтайваны өргөн чөлөө 46А
Улаанбаатар хот 13348 ШХ-48
Утас: (976-51) 263860
Факс: (976-11) 458032
Цахим шуудан: standardinform@masm.gov.mn
Цахим хуудас: www.estandart.gov.mn,
www.masm.gov.mn

СХЗГ 2021

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын Төв байгууллага) -т байна.

АГУУЛГА

ОРШИЛ.....	1
1 Хамрах хүрээ	2
2 Норматив эшлэл.....	2
3 Нэр томьёо, тодорхойлолт.....	3
3.1 Үндсэн агуулгад хамаарах ойлголт	3
3.2 Атрибутын утгын төрөлд /Value Type/ хамаарах ойлголт.....	4
4 Техникийн шаардлага.....	5
4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих (норматив) шаардлага.....	5
4.2 Атрибутад тавигдах (норматив) шаардлага.....	6
4.3 Кодын жагсаалтад тавих (норматив) шаардлага.....	7
4.4 UML диаграмм (норматив).....	7
4.5 Өгөгдлийн чанарт тавих (норматив) шаардлага.....	7
A Хавсралт – Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга	8
B Хавсралт – Кодын жагсаалт	15
C Хавсралт – UML диаграмм	25
D Хавсралт – Өгөгдлийн чанар.....	28

ОРШИЛ

Энэхүү стандартын зорилго нь байрлалд суурилсан орон зайн суурь өгөгдлийг нэгдсэн мэдээллийн системд оруулах, бүрдүүлэх, мэдээллийг тогтмол шинэчлэх, солилцох үйл ажиллагаанд баримтлах өгөгдлийн сангийн бүтэц, агуулга, техникийн шаардлагыг бүрэн хэмжээнд тодорхойлох явдал юм.

Стандартыг баримталсны үр дүнд геопорталаар дамжуулан байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийн цахим үйлчилгээнүүдийг хэрэглээнд нэвтрүүлэх, нэгдсэн мэдээллийг нэг эх үүсвэрээс ашиглах, үйл ажиллагааны суурь нөхцөлийг бүрдүүлэх, эрчимтэй хөгжих боломжийг олгоно.

Энэхүү стандарт нь нэг талаас орон зайн өгөгдлийн санг хариуцагч байгууллага нөгөө талаас орон зайн өгөгдөл, мэдээлэлтэй хамаарал бүхий үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, хувь хэрэглэгч нарын хооронд үүсэх өгөгдөл бүрдүүлэх, боловсруулах, шинэчлэх, хадгалах, солилцох бүх харилцаанд үйлчилж нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгоход ашиглах үндсэн баримт бичиг болно.

Стандартын техникийн шаардлагуудыг Европын холбооны хүрээлэн буй орчинд нөлөөлөх бодлого, үйл ажиллагааг зохицуулах Европын орон зайн мэдээллийн дэд бүтэц INSPIRE (Infrastructure for Spatial Information in Europe) системийн техникийн тодорхойлолт, олон улсын стандартын байгууллага (ISO)-ын TX 211 (ISO/TC 211-Geographic information/Geomatics) -с гаргасан ISO 19100 цуврал стандартуудын үзүүлэлт, шаардлагад тулгуурлаж, Монгол Улсад мөрдөж буй стандарт, норм, дүрэм, журам, орон зайн суурь өгөгдлийн бүтэц, агуулга, ангиллыг үндэслэл болгон боловсруулав.

Мөн орон зайн суурь өгөгдлийн техникийн шаардлагуудыг мэдээллийн сангийн загварыг дүрслэх Загварчлалын Нэгдмэл Хэл (UML-Unified Modeling Language) -ийн дагуу нийцүүлэн боловсруулав.

Стандарт бүтэц нь орон зайн өгөгдлийн загвар, өгөгдлийн сангийн агуулга, орон зайн объектын төрөл, атрибут, кодын жагсаалт, UML диаграммаас бүрдэнэ.

Уг стандарт нь түүх, соёл, археологийн өв орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, тайлагнах, үйлчлэх зорилгоор өгөгдлийг системтэй, уялдаатай болгон бүрдүүлэхэд чиглэнэ.

Түүх, соёл, археологийн өв орон зайн суурь өгөгдөлд бодит биет байдлаар орших үл хөдлөх дурсгалын байршил, төрөл зүйл, тэдгээрийн хамрах хүрээ, хамгаалалтын хүрээ, байгалийн болон хүнээс нөлөөлөх хүчин зүйлүүд зэрэг мэдээллийг агуулж, энэ нь хот төлөвлөлт, газар зохион байгуулалт, газар ашиглалт, газар тариалан эрхлэх, уул уурхай, орчны нөлөөллийг тооцоолох зэргээр бодлого, менежментийг сайжруулах замаар боловсруулалт хийж ашиглах боломжийг олгоно.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангиллын код: 35.240.70

Газар зүйн мэдээлэл. Түүх, соёл, археологийн өвийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS ... : 2021
Geographic information. Data specification on Historical, cultural and archaeological heritage	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны дугаар сарынний өдрийн дугаар тушаалаар батлав

Энэхүү стандарт нь батлагдсан өдрөөс эхлэн хүчинтэй.

Стандартын шаардлага нь заавал мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Түүх, соёл, археологийн өв орон зайн суурь өгөгдлийн сан нь түүх, соёлын дурсгалт газартай холбоотой бүх элементүүд болох үл хөдлөх дурсгалын газар зүйн байршил, түүхэн цаг үе, төрөл зүйлийн ангилал, хамрах хүрээ, хамгаалалт, байгалийн болон хүний хүчин зүйлийн нөлөөлөл, малтлага, судалгаа, сэргээн засварлах, тэдгээрийн мэдээллийг агуулахад хамаарна.

Энэхүү стандарт нь түүх, соёл, археологийн өвийн орон зайн суурь өгөгдлийн сангийн бүтэц, стерео төрлүүд, атрибут мэдээллийн шаардлага, UML диаграмм (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language), өгөгдлийн чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлоход хамаарна.

Монгол улсын нийт газар нутгийн хэмжээнд түүх, соёл, археологийн өвийн орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, шинэчлэх, хөтлөх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжид хамаарна.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

ISO 19103: 2005, Газар зүйн мэдээлэл – Үзэл баримтлалын схем;

ISO 19107: 2005, Газар зүйн мэдээлэл – Орон зайн схем;

ISO 19108: 2005, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем;

ISO 19111: 2007, Газар зүйн мэдээлэл – Солбицлоор илэрхийлэгдсэн орон зайн дүрслэл;

ISO 19113: 2005, Газар зүйн мэдээлэл – Чанарын зарчим;

ISO 19118: 2006, Газар зүйн мэдээлэл – Кодлолт;

ISO 19125-1: 2004, Газар зүйн мэдээлэл – Энгийн биетийн хандалт - 1-р хэсэг: Нийтлэг архитектур;

ISO 19135: 2007, Газар зүйн мэдээлэл – Бүртгэлийн явц;
ISO/TS 19138: 2006, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанарын хэмжүүр;
ISO/TS 19139: 2007, Газар зүйн мэдээлэл – Мета өгөгдөл – XML схемийн хэрэгжилт;
ISO/DIS 19157, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанар;
MNS 5774:2007 Газар зүйн мэдээлэл – Мета өгөгдөл
MNS ISO/TS 19104:2012 Газар зүйн мэдээлэл - Нэр томьёо

3 Нэр томьёо, тодорхойлолт

Энэхүү стандарт ба түүнд холбогдох бусад стандартын хувьд дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1

Үндсэн агуулгад хамаарах ойлголт

3.1.1

орон зайн өгөгдөл

газрын гадарга дээрх болон доорх, ус, агаар, сансрын орон зайд орших байгалийн болон хүний үйл ажиллагаагаар бүтээгдсэн биет юмс, үзэгдлийн байрлал, хил зааг, түүний шинж чанарыг тодорхойлсон мэдээллийн цогц.

3.1.2

орон зайн суурь өгөгдөл

харьцангуй урт хугацаанд үл өөрчлөгдөх, оролцогч талуудын хэрэгцээг нийтлэгээр хангах боломжтой, үндсэн буюу голлох мэдээлэл гэж тодорхойлсон орон зайн өгөгдөл.

3.1.3

өгөгдлийн багц

өгөгдлийн сангийн нэг сэдэвчилсэн агуулгын хүрээнд багтах хэд хэдэн өгөгдлийн цуглуулга.

3.1.4

стерео төрөл

стандартад ашиглаж байгаа биет болон атрибутын ижил төстэй шинж чанарыг харгалзан үүсгэсэн ангилал, төрлийг.

3.1.5

өгөгдөл төрөл

ямар нэгэн геометр дүрслэл агуулаагүй, өгөгдлийн сэдэвчилсэн утга, хэмжээс, формат зэргийг илэрхийлэгч, хэд хэдэн үзүүлэлтүүдийг агуулсан төрлийг.

3.1.6

биет төрөл

орон зайн агуулга бүхий геометр биетээр дүрслэгдсэн болон дүрслэх боломжтой биетийг илэрхийлэгч төрөл.

3.1.7

кодын жагсаалт

биетийн төрөл эсвэл өгөгдлийн төрлийн атрибутадад ашиглах урьдчилан боловсруулж үүсгэсэн ангиллын утгын жагсаалт.

3.1.8

домэйн

Тухайн сэдвийн үзүүлэлтийн агуулгын хүрээг илэрхийлнэ. Тухайлбал, хэмжээс /measure/ заасан утгын төрөлд “хэмжсэн тоон утга” л байх ёстой гэсэн шалгуур домэйн болно.

3.2

Атрибутын утгын төрөлд /Value Type/ хамаарах ойлголт

3.2.1

Boolean

Тухайн мэдээлэл үнэн эсвэл худлаа гэсэн хоёр боломжит утгын аль нэгийг сонгоход хэрэглэдэг утгын төрөл юм (ихэвчлэн тийм бөгөөд үгүй гэсэн төрөл ашигладаг). [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.3

Character string

Тэмдэгтийн мөр. Бичиглэхэд ашигладаг тэмдэгтүүдийн жагсаалт. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.4

Date time

Цаг хугацааг заасан утгын төрөл. Огноо, цагийн хослол хэлбэрээр байна. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.5

Identifier

Өгөгдөл мэдээллийг хариуцагч эрх бүхий байгууллагаас олгосон орон зайн объектын танигч буюу тодорхойлогч. Энэ нь тухайн өгөгдлийг бусад программ, системүүд лавлах, холбох үед ашиглана. [Дэлгэрэнгүй мэдээллийг: INSPIRE DS-D2.5]

3.2.6


Measure

Хэмжилтийн үр дүнд гаргасан хэмжигдэхүүний тоон утга. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

4 Техникийн шаардлага

4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих (норматив) шаардлага

4.1.1 Орон зайн өгөгдлийн сан нь өгөгдлийг сэдэв, агуулгаас хамааруулан багцалсан хэлбэр болох “**өгөгдлийн багц**”, өгөгдлийн багц дотор агуулагдах стерео төрлүүд, өгөгдөл тус бүрийн дэлгэрэнгүй “**атрибут**”, атрибутад орох мэдээллийг төрөлжүүлж ангилсан “**кодын жагсаалт**” гэсэн хэсгүүдээс тогтсон бүтэцтэй (1-р зурагт тоймлон үзүүлэв) байхыг шаардана.



1-р зураг – Түүх, соёл, археологийн өвийн өгөгдлийн сангийн бүтэц, агуулга

4.1.2 А хавсралтаар орон зайн өгөгдлийн сангийн багц тус бүрээр биет төрлүүд тэдгээрт хамаарах өгөгдөл төрөл, биет төрөл болон өгөгдөл төрлийн атрибут, атрибутын талбарт оруулах утга болон утгын төрлийн норматив шаардлагыг заана.

4.1.3 В хавсралтаар кодын жагсаалтын норматив шаардлагыг тодорхойлно. Кодын жагсаалт нь атрибутын талбарт оруулах утганд ашиглах тогтмол утга бүхий ангилал гэж ойлгоно.

4.1.4 Орон зайн өгөгдлийн сангийн багцад орсон өгөгдөл нь А хавсралтын А.1-р хүснэгтэд үзүүлсэн «биет төрөл», «өгөгдөл төрөл», «кодын жагсаалт» гэсэн стерео төрөлтэй байх норматив шаардлагыг хангана.

4.1.5 Биет төрөл тус бүрийн орон зайн дүрслэлийг А хавсралтын А.1-р хүснэгтэд “Биетийн төрөл” баганад үзүүлсэн шаардлагын дагуу дүрсэлнэ.

4.1.6 Өгөгдлийн нэрийг монгол, англи хэлээр нэрлэх бөгөөд мэдээллийг бүрдүүлэхдээ тодорхойлолтоор илэрхийлсэн агуулгын дагуу байхыг шаардана.

4.1.7 Түүх, соёл, археологийн өвийн орон зайн суурь өгөгдлийн сан нь А хавсралтын А.1-р хүснэгтийн дагуу Түүх, соёлын үл хөдлөх дурсгал гэсэн 1 өгөгдлийн багцаас бүрдсэн байна.

4.1.8 Түүх, соёлын үл хөдлөх дурсгал орон зайн өгөгдлийн санд 2 биет төрөл агуулна.

4.2 Атрибурад тавигдах (норматив) шаардлага

4.2.1 Өгөгдлийн атрибут мэдээлэл нь өгөгдөл тус бүрээр А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсэн норматив шаардлагыг хангана.

4.2.2 Атрибут нь А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсний дагуу атрибутын нэрийг монгол, /англи хэл/-ээр нэрлэх, “талбарт оруулах утга”, “утгын төрөл”, “тэмдэгтийн урт” гэсэн шаардлагыг хангахаас гадна тодорхойлолтод тусгасан мэдээллийн агуулгын дагуу бүрдүүлэлт, бичиглэлийг хийсэн байхыг шаардана.

4.2.3 Орон зайн өгөгдлийн сангийн биет төрөл нь давтагдашгүй гадаад танигч атрибутыг агуулах шаардлагатай. Гадаад танигч /External id/ нь орон зайн объектын танигч нь өгөгдлийн сангийн гадаад танигч үүсгэхэд ашиглах тусгай танигч код бөгөөд “дотоод танигч” /Local id/, “нэрийн талбар” /Name space/, “танигчийн хувилбар” /Version id/ гэсэн 3 атрибутаас бүрдэнэ [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005].

4.2.3.1 “Дотоод танигч /Local id/” нь тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байхыг шаардана.

4.2.3.2 “Нэрийн талбар /Name space/” нь өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.

4.2.3.3 “Танигчийн хувилбар /Version ID/” нь орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэсэн байхыг шаардана.

4.2.4 Түүх, соёл, археологийн өвийн орон зайн суурь өгөгдлийн сан нь 4.2.4.1-д заасан “Газар зүйн нэр” /Geographical name/ орон зайн дэд өгөгдлийн сантай холбогдоно.

4.2.4.1 “Газар зүйн нэр” /Geographical name/ нь тухайн дурсгалт газрын “Нэр” /Name/ гэх атрибутаар холбогдох бөгөөд талбарт оруулах утгад «Газар зүйн нэр» гэсэн «өгөгдөл төрөл»-ийг ашиглах бөгөөд түүний агуулгыг “Газар зүйн мэдээлэл. Газар зүйн нэрийн өгөгдлийн үзүүлэлт MNS:2021” стандартаас авч ашиглана.

4.3 Кодын жагсаалтад тавих (норматив) шаардлага

4.3.1 А хавсралтын А.1-р хүснэгтэд кодын жагсаалтын тодорхойлолт, В хавсралтад кодын жагсаалтын кодын утга, түүний тодорхойлолтын дагуу норматив шаардлагыг хангана.

4.3.2 Түүх, соёл, археологийн өвийн орон зайн өгөгдлийн санд 9 кодын жагсаалт агуулна.

4.3.3 А хавсралтын А.2 хүснэгтэд заасан атрибутын талбарт оруулах утгад заасан кодын жагсаалтын дагуу ангиллын утгыг сонгож оруулах нөхцөлөөр ашиглана.

4.4 UML диаграмм (норматив)

4.4.1 Орон зайн объектын төрөл, атрибут, утгын төрөл, тэдгээрийн холбоосыг С хавсралтад үзүүлсэн UML диаграмм (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language)-ын дагуу өгөгдлийг загварчилна.

4.4.2 Орон зайн өгөгдлийг загварчлах, боловсруулалтыг автоматжуулах, хэрэглээний схемд суурилсан өөр өөр түвшний өгөгдлийг уялдуулахад С хавсралтад үзүүлсэн UML диаграммыг ашиглана.

4.4.3 С хавсралтад үзүүлсэн UML диаграммаас гадна түүх, соёл, археологийн өвийн орон зайн суурь өгөгдлийн сантай хамааралтай бусад орон зайн суурь өгөгдлийн сангийн UML диаграммыг ашиглахыг зөвшөөрнө.

4.5 Өгөгдлийн чанарт тавих (норматив) шаардлага

4.5.1 Өгөгдлийн чанарт тавигдах шаардлага нь түүх, соёл, археологийн өвийн орон зайн суурь өгөгдлийн нэгжийн чанарыг үнэлэх, баримтжуулах зорилготой чанарын элементүүдийн шаардлагыг D Хавсралтын D.1.1 - D.1.13-р хүснэгтэд үзүүлснээр дагаж мөрдөнө. Эдгээр шаардлага нь ISO 19157 олон улсын стандартад заасан чанарын үзүүлэлтүүд бөгөөд энэ стандартад ерөнхий шаардлагуудыг дагаж мөрдөнө.

4.5.2 Түүх, соёл, археологийн өвийн орон зайн суурь өгөгдлийн сангийн өгөгдлийн нэгж болох багц, биет төрөл, өгөгдөл төрлүүд нь өгөгдлийн чанарын дараах ерөнхий шалгуур үзүүлэлтийг хангана. Үүнд:

4.5.2.1 Иж бүрдэл: биет болон тэдгээрийн атрибут, харилцан хамаарлуудын түвшин.

4.5.2.2 Утга агуулгын нийцтэй байдал: өгөгдлийн бүтэц, атрибут ба харилцан хамаарлуудын логик дүрмүүдийг баримтлах түвшин.

4.5.2.3 Байршлын нарийвчлал: орон зайн объектын байршлын нарийвчлалын түвшин.

4.5.2.4 Сэдэвчилсэн нарийвчлал: тоон атрибутуудын нарийвчлал ба тоон бус атрибутуудын бодит байдал болон биет, тэдгээрийн харилцан хамаарлын түвшин.

ТӨГСӨВ

А Хавсралт
(норматив)

Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга

А. 1-р хүснэгт – Түүх, соёл, археологийн өв орон зайн суурь өгөгдлийн багц болон жагсаалт

А.1.1 Өгөгдлийн багц: Түүх, соёлын үл хөдлөх дурсгал өгөгдөл (Immovable historical and cultural monuments)

Д/д	Өгөгдлийн нэр	Стереo төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Үл хөдлөх дурсгал / <i>Immovable monument</i> /	«биет төрөл» /feature type/	Цэг	Түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд бүх талын үнэт ач холбогдол бүхий уран барилга, сүрлэг чимэглэлийн уран баримал, уран зургийн бүтээл, археологийн олдвор, бичээс, агуй болон цогцолбор дурсгал хамаарна.
2	Дурсгалын хамрах хүрээ / <i>Monument site</i> /	«биет төрөл» /feature type/	Полигон	Хүний болон хүн, байгалийн хамтарсан бүтээлүүд мөн түүх, гоо зүй, угсаатны судлалын хувьд бүх талын үнэт ач холбогдол бүхий археологи, түүхийн дурсгалт газрыг багтаасан бүс нутгийг хэлнэ.
3	Үл хөдлөх дурсгалын үндсэн ангилал / <i>Immovable monument major type value</i> /	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Үл хөдлөх дурсгалыг түүх болон археологийн соёлын өвийн чиглэлээр төрөл зүйлээр ангилсан байдал.
4	Үл хөдлөх дурсгалын дэд ангилал / <i>Immovable monument sub type value</i> /	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Үл хөдлөх дурсгалыг түүх болон археологийн соёлын өвийн чиглэлээр төрөл зүйлээр дэд ангилалд хуваасан байдал.
5	Үл хөдлөх дурсгалын анхдагч ангилал / <i>Immovable monument primary type value</i> /	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Үл хөдлөх дурсгалыг түүх болон археологийн соёлын өвийн чиглэлээр төрөл зүйлээр нь анхдагч ангилалд хуваасан байдал.
6	Үл хөдлөх дурсгалын чулуулгийн төрөл / <i>Solid type value</i> /	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Түүх, соёлын дурсгалын чулуулгийн материалын төрлийг илэрхийлнэ.

7	Хүний үйл ажиллагаагаар учирсан гэмтлийн төрөл <i>/Anthropogenic damage type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Хүний санаатай болон санамсаргүй үйл ажиллагааны төрөл.
8	Байгалийн хүчин зүйлээр учирсан гэмтлийн төрөл <i>/Natural damage type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Байгалийн гамшигт үзэгдлүүд болон ургамал, мал амьтны нөлөө.
9	Хүрээний төрөл <i>/Zone type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Үл хөдлөх дурсгалын хамгаалалтын хүрээ эсвэл хамрах хүрээг тодорхойлно.
10	Үл хөдлөх дурсгалын хамгаалалтын ангилал <i>/Protection type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Тухайн түүх, соёлын дурсгалын хамгаалалтын зэрэглэлийн түвшнийг тодорхойлно.
11	Хамгаалалтын зэрэглэл өөрчлөх санал <i>/Protection change proposal</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Тухайн түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын хамгаалалтын зэрэглэл нь засаг захиргааны удирдлагын аль түвшинд шилжихийг заана.

А. 2-р хүснэгт - Орон зайн өгөгдлийн дэд сангийн биет төрлийн атрибутын агуулга

А.2.1 Өгөгдлийн багц - Түүх, соёлын үл хөдлөх дурсгал (Immovable historical and cultural monuments)

А.2.1.1 Өгөгдлийн нэр: Үл хөдлөх дурсгал (Immovable monument)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	ГМ Цэг /GM_Point/	-	-	Сонгосон орон зайн лавлах систем дэх координатаар илэрхийлсэн цэгийн байрлал.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	200	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	Мэдээлэл засварласан, устгасан огноо /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
7	Нэр /Name/	«Газар зүйн нэр» «Geographical name»	-	-	Үл хөдлөх дурсгалын оршин байгаа газрын нэрийг тодорхойлно.
8	Дурсгалын нэр /Monument name/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	200	Үл хөдлөх дурсгалын нэрийг бичнэ. /нэмэлт нэр, өөр дуудлага, түүхэн нэр болон эксоним нэрийг оруулах боломжийг олгоно/.

9	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн ангилал /Administrative unit sub class/	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дэд ангилал /Administrative unit sub class value/	-	-	Дурсгалын байршлыг илэрхийлэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн сум, дүүргийн ангилал. Хил заагийн орон зайн дэд өгөгдлийн сангийн Administrative unit sub class value - кодын жагсаалтын утгаас авч ашиглана.
10	Үл хөдлөх дурсгалын үндсэн төрөл /Immovable monument major type/	Үл хөдлөх дурсгалын үндсэн ангилал /Immovable monument major type value/	-	-	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын ерөнхий буюу үндсэн төрлийг илэрхийлнэ. Immovable monument major type value – кодын жагсаалтаас авна.
11	Үл хөдлөх дурсгалын дэд төрөл /Immovable monument sub type/	Үл хөдлөх дурсгалын дэд ангилал /Immovable monument sub type value/	-	-	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын дэд төрлийг илэрхийлнэ. Immovable monument sub type value – кодын жагсаалтаас авна.
12	Үл хөдлөх дурсгалын анхдагч төрөл /Immovable monument primary type/	Үл хөдлөх дурсгалын анхдагч ангилал /Immovable monument primary type value/	-	-	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын анхдагч ангиллыг илэрхийлнэ. Immovable monument primary type value – кодын жагсаалтаас авна.
13	Үл хөдлөх дурсгалын чулуулгийн төрөл /Solid type/	Үл хөдлөх дурсгалын чулуулгийн төрөл, /сангилал /Solid type value/	-	-	Тухайн чулуун дурсгалыг урласан материалыг сонгож бичих. Solid type value – кодын жагсаалтаас авна.
14	Тодорхойлолт /Definition/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	300	Тухайн дурсгалт газрын шинж чанар, хэлбэр, хэмжээ, тоо ширхэг, хийсэн материал, хадгалалт хамгаалалтын байдал зэргийг тоочин тэмдэглэл хөтөлж бичих.
15	Урт /Length/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	5	Дурсгалын уртын хэмжээ.
16	Өргөн /Width/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	5	Дурсгалын өргөний хэмжээ.
17	Өндөр /Height/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	5	Дурсгалын өндрийн хэмжээ.

18	Зузаан /Depth/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	5	Дурсгалын зузаан.
19	Голч /Diameter/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	5	Дурсгалын голч буюу диаметрийн хэмжээ.
20	Дэлхийн өвд бүртгэгдсэн эсэх /World heritage inscribed/	Логик /Boolean/	Логик /Boolean/	10	Дурсгалт газрыг дэлхийн өвд бүртгэгдсэн эсэхийг тодорхойлно.
21	Тусгай хамгаалалтад авах хэрэгцээ /Special protection requirement/	Логик /Boolean/	Логик /Boolean/	10	Дурсгалт газрыг тусгай хамгаалалтад авах шаардлагатай эсэх.
22	Яаралтай авран хамгаалах шаардлагатай эсэх /Urgent protection requirement/	Логик /Boolean/	Логик /Boolean/	10	Дурсгалт газрыг яаралтай авран хамгаалах шаардлагатай эсэх.
23	Өмчлөл, эзэмшил, ашиглалтын байдал /Ownership change proposal/	Логик /Boolean/	Логик /Boolean/	10	Дурсгалт газрыг өмчлөх, эзэмших болон ашиглаж буй байдлыг өөрчлөх саналтай эсэхийг тодорхойлно.
24	Сэргээн засварласан эсэх /Repair/	Логик /Boolean/	Логик /Boolean/	10	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрыг сэргээн засварлаж, янзалсныг тодорхойлно.
25	Сэргээн засварлах шаардлагатай эсэх /Repair requirement/	Логик /Boolean/	Логик /Boolean/	10	Тухайн түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрыг сэргээн засварлах шаардлагатай эсвэл шаардлагагүй гэдгийг тогтооно.
26	Хүний үйл ажиллагаагаар учирсан гэмтлийн төрөл /Anthropogenic damage type/	Хүний үйл ажиллагаагаар учирсан гэмтлийн ангилал /Anthropogenic damage type value/	-	-	Хүний санаатай болон санамсаргүй үйл ажиллагааны нөлөөлөл. Anthropogenic damage type value - харгалзах кодын жагсаалтаас авч ашиглана.
27	Байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр учирсан гэмтлийн төрөл /Natural damage type/	Байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр учирсан гэмтлийн ангилал /Natural damage type value/	-	-	Байгалийн гамшигт үзэгдлүүд болон ургамал, мал амьтны нөлөөлөл. Natural damage type value - харгалзах кодын жагсаалтаас авч ашиглана.

A.2.1.2 Өгөгдлийн нэр: Дурсгалын хамрах хүрээ (Monument site)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	ГМ Объект /GM_Object/	-	-	Сонгосон орон зайн лавлах систем дэх координатаар илэрхийлсэн байрлал.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	200	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	Мэдээлэл засварласан, устгасан огноо /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
7	Дурсгалт газрын нэр /Name/	«Газар зүйн нэр» «Geographical name»	-	-	Дурсгал оршиж байгаа газар болон тухайлсан нэрийг бичнэ. Газар зүйн нэрийн орон зайн өгөгдлийн дэд сангаас авна.
8	Хүрээний төрөл /Zone type/	Хүрээний төрөл, ангилал /Zone type value/	-	-	Дурсгалын хамрах хүрээ, хамгаалалтын хүрээний аль болохыг тодорхойлно. Zone type value - кодын жагсаалтаас авч ашиглана.
9	Тоо ширхэг /Quantity/	Хэмжээс /Measure/	Бүхэл тоо /Integer/	5	Хэрэв дурсгалт газрын дурсгалыг тоймлон тоолсон бол энэ хэсэгт тоон утгаар оруулна.

10	Хамгаалалтын төрөл /Protection type/	Хамгаалалтын төрөл, ангилал /Protection type value/	-	-	Дурсгалт газрыг улсын аль шатны хамгаалалтад авсан эсэхийг тодорхойлно. Protection type value – кодын жагсаалтаас авч ашиглана.
11	Хамгаалалтын зэрэглэл /Protection level/	Хамгаалалтын зэрэглэл өөрчлөх саналын ангилал /Protection change proposal/	-	-	Тухайн түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын хамгаалалтын зэрэглэл нь засаг захиргааны удирдлагын аль түвшинд шилжихийг заана. Protection change proposal – кодын жагсаалтаас авч ашиглана.
12	Хамгаалалтын бүс тогтоох /Protection zone requirement/	Логик /Boolean/	Логик /Boolean/	10	Дурсгалт газарт хамгаалалтын бүс тогтоох шаардлагатай эсэхийг шийдвэрлэнэ.
13	Хамгаалалтын бүсийн талбай /Protection zone area/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	5	Дурсгалт газарт хамгаалалтын бүс тогтсон бол талбайн хэмжээг илэрхийлнэ.
14	Өндрийн хэмжээ /Elevation/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	5	Дурсгалын оршиж байгаа газрын өндрийн хэмжээ.
15	Малтан судалсан эсэх /Archaeological excavation/	Логик /Boolean/	Логик /Boolean/	10	Тухайн дурсгалт газрыг мэргэжлийн судалгааны байгууллага судлан шинжлэх зорилгоор малтсан эсэхийг тодорхойлно.

В Хавсралт
(норматив)

Кодын жагсаалт

В.1 Өгөгдлийн багц - Түүх, соёлын үл хөдлөх дурсгал (Immovable historical and cultural monuments)

В.1.1 Үл хөдлөх дурсгалын үндсэн ангилал – Immovable monument major type value

Д/д	Ангиллын утга	Тодорхойлолт
1	Чулуун зэвсгийн дурсгалт газар /stoneAgeSite/	Чулуун зэвсгийн дурсгалт газар.
2	Хадны зураг, бичгийн дурсгал /rockArtAndInscription/	Хадны зураг, бичгийн дурсгал.
3	Булш, оршуулгын дурсгал /burialSite/	Булш, оршуулгын дурсгал.
4	Тахил, тайлгын байгууламж /sacrificialSite/	Тахил, тайлгын байгууламж.
5	Барилга, архитектурын дурсгал /architecturalAndBuildingSite/	Барилга, архитектурын дурсгал.
6	Хөшөө дурсгал /monument/	Хөшөө дурсгал.
7	Үйлдвэрлэлийн ул мөр хадгалсан дурсгалт газар /ProductionSite/	Үйлдвэрлэлийн ул мөр хадгалсан дурсгалт газар.
8	Палеонтологийн дурсгалт газар /paleontologicalSite/	Палеонтологийн дурсгалт газар.

В.1.2 Үл хөдлөх дурсгалын дэд ангилал – Immovable monument sub type value

Д/д	Дэд ангилал	Үндсэн ангилал
1	Палеолит /Palaeolithic/. Хуучин чулуун зэвсгийн үе (МЭӨ 800.000-12.000 жил)	Чулуун зэвсгийн дурсгалт газрын ангилал /stoneAgeSiteTypeValue/
2	Мезолит /Mesolithic/. Дундад чулуун зэвсгийн үе (МЭӨ 12.000-7.000 жил)	
3	Неолит /Neolithic/. Шинэ чулуун зэвсгийн үе (МЭӨ 7.000-3.000 жил)	

4	Хүний сууж байсан оромж, сууц, агуй /Cave and dwelling site/. Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн орогнож байсныг гэрчлэх олдвор бүхий дурсгалт агуй, нүхэн сууц зэргийг хэлнэ.	Хадны зураг, бичгийн дурсгалын ангилал /rockArtAndInscriptionTypeValue/	
5	Бусад /Other/.		
6	Сийлмэл зураг /Petroglyphs/. Байгалийн тогтцоороо байгаа хад чулууны гадаргуу дээр хүн, мал, амьтан болон бусад зүйлсийн зургийг тусгай багаж зэвсэг ашиглан сийлж зурсан бүх төрлийн хадны сийлмэл зургуудыг хамаарна.		
7	Зос, бэхэн зураг /Ochre painting/. Байгалийн тогтцоороо байгаа хад чулууны гадаргуу дээр хүн, мал, амьтан болон бусад зургийг тусгай найрлага бүхий зос, бэх, шороон будаг ашиглан зурсан бүх төрлийн хадны зургийг хамааруулна.		
8	Тамга, тэмдэг, бичгийн дурсгал /Stamps symbols and inscription monument/. Байгалийн тогтцоороо байгаа хад чулууны гадаргуу дээр овгийн тамга болон тодорхой үсэг бичгийг ашиглан зос, бэх болон сийлбэрлэн гаргасан бүх төрлийн тамга тэмдгийн дурсгалыг хамааруулна.		
9	Неолитын булш /Neolithic burial/. Неолит буюу шинэ чулуун зэвсгийн үед хамаарах булш оршуулгын дурсгал.		Булш оршуулгын дурсгалын ангилал /burialSiteTypeValue/
10	Шоргоолжин булш /Shaped burial/. Хүрлийн үеийн булш оршуулгын дурсгал.		
11	Хиргисүүр /Khirgisuur/. Эртний хүмүүс чулуугаар том хэмжээний чулуун овоолго үйлдэж, түүнийхээ гадуур хүрээ татаж олон жижиг дугуй чулуун байгууламж дагалдуулан бүтээсэн бүх төрлийн хиргисүүрийн байгууламжууд хамаарна.		
12	Дөрвөлжин булш /Slab burial/. Хүрлийн үед хамаарах булш оршуулгын дурсгал.		
13	Пазырык булш /Pazyrik burial/. Түрүү төмрийн үеийн Алтайн нурууны археологийн соёлыг хадгалсан дурсгал.		
14	Хүннү булш /Xiongnu burial/. Хүннүгийн үед хамаарах булш оршуулгын дурсгал.		
15	Түрэг булш /Turkic burial/. Эртний Түрэгийн үед хамаарах булш оршуулгын дурсгал.		
16	Уйгур булш /Uyghur burial / . Уйгурын үеийн булш оршуулгын дурсгал.		
17	Хятан булш /Kitan burial/. Хятаны үеийн булш, оршуулгын дурсгал.		
18	Монгол булш /Mongol burial/. Дундад зууны монголчуудын булш, оршуулгын дурсгал.		

19	Хадны оршуулга /Cave burial/. Эртний нүүдэлчдийн хадны хөмөг агуйд үхэгсдээ оршуулах өвөрмөц хэлбэр.	Тахил тайлгын байгууламжийн ангилал <i>/sacrificialSiteTypeValue/</i>
20	Бусад /Other/.	
21	Тахилын онгон /Sacrificial site/.	
22	Тахилын сүмийн туурь /Sacrificial temple ruins/. Түүхэн тодорхой цаг үед хүмүүс тахил тайлга хийх газар болгон барьж байгуулсан тахилын сүмүүд хамаарна.	
23	Шивээ /Fence/. Өвс, мод, бургас зэргийг босгон тогтоож барьсан хашаа хороо.	
24	Овоо /Hillock/. Хүмүүсийн байгаль дэлхийгээ хамгаалах, газар орныхоо хилийн цэсийг тогтоох зэрэгтэй холбоотойгоор чулууг овоолон босгосон бүх төрлийн овоо хамаарна.	
25	Бусад /Other/.	Барилга, архитектурын дурсгалын ангилал <i>/architecturalAndBuildingSiteTypeValue/</i>
26	Суурьшлын ул мөр бүхий газар /Traces of an ancient settlement place/. Түүхэн тодорхой цаг үед хүмүүс богино, урт хугацаагаар суурьшин амьдарч байсныг илтгэх эртний хот суурин, цайз, хэрмийн үлдэгдэл, барилга, байшин, бууц бүхий газар зэргийг ерөнхийлөн хамаарна.	
27	Эртний хот /Ancient settlement / city/. Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн оршин сууж байсан болон, цэргийн бэхлэлт болгон барьж байгуулсан барилга байшин, хэрмийн үлдэгдэл хамаарна.	
28	Хэрмэн зам /Wall road/.	
29	Шуудуу /Canal/. Ус урсгах гэж зориудаар ухсан болон үер усны нөлөөгөөр үүссэн суваг.	
30	Сүм хийдийн туурь /Temple ruins/. Түүхэн тодорхой цаг үед шашны хурал номын үйл ажиллагаа явуулж байсан болон мөргөл, хүндэтгэлийн үүргийг гүйцэтгэж байгаад хожим нь эвдэрч сүйдсэн, эргэж сэргээн засварлагдсан сүм хийд түүний туурь үлдэгдлүүд хамаарна.	
31	Суварга /Stupa/. Түүхэн тодорхой цаг үед шашны хурал номын үйл ажиллагаа явуулж байсан болон мөргөл, хүндэтгэлийн үүргийг гүйцэтгэж байгаад хожим нь эвдэрч сүйдсэн, эргэж сэргээн засварлагдсан суварга түүний туурь үлдэгдлүүд хамаарна.	
32	Түүхэн дурсгалт байшин /Historical monument building/. Түүхэн тодорхой цаг үед баригдаж хот байгуулалт, уран барилгын түүхийн аль нэг хэсгийг төлөөлж чадах болон	

	түүхэн үйл хэргийн бодит дурсгал болж үлдсэн, нэрт хүмүүсийн ажиллаж, амьдарч байсан бүх төрлийн барилга байшин, орон сууцны барилга хамаарна.	
33	Агуй, оромж, түр сууц /Cave, dwelling/.	
34	Архитектурын дурсгал /Architectural monument/. Түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд бүх талын үнэт ач холбогдол бүхий салангид буюу нэгдмэл барилга байгууламж, уран барилгын цогцолбор хамаарна.	
35	Бусад /Other/.	
36	Буган хөшөө /Deer stone/. Байгалийн гонзгой урт чулууг засаж янзлан /зарим тохиолдолд засаагүй байдаг/ гадаргуун дээд хэсэгт нар, сар дунд хэсгээр буга, доод хэсгээр нь бүс, зэр зэвсэг зэргийг сийлж цоолборлож үйлдсэн хөшөө дурсгалыг хамруулдаг.	<p style="text-align: center;">Хөшөө дурсгалын ангилал /monumentTypeValue/</p>
37	Хүн чулуу /Human stone/. Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн байгалийн чулууг засаж янзлан хүний биеийн төрх гарган сийлсэн бүх төрлийн хөшөө дурсгал хамаарна.	
38	Тамга, тэмдэгтэй хөшөө чулуу /Stone statue with stamps and symbols/. Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн байгалийн чулууг засаж янзлан гадаргуу дээр нь ямар нэг бичиг үсэг хэрэглэн түүхэн хэрэг явдал болон бусад зүйлсийн талаар бичиж үлдээсэн бичвэр бүхий хөшөөд хамаарна.	
39	Гэрэлт хөшөө /Statue/. Баатарлаг гэгээн зүйлсийг тунхаглан бататган сийлэн болгосон хөшөө.	
40	Амьтны дүрслэлтэй хөшөө /Statues with animal inscriptions/. Түүхэн тодорхой цаг үед хүмүүс амьтан эрхэмлэх зан үйлтэй холбоотойгоор байгалийн чулууг засаж янзлан амьтны дүрс гарган урлаж хийсэн чулуун дурсгалууд хамаарна.	
41	Цулгуй хөшөө /Plain statue/.	
42	Бусад /Other/.	
43	Төмөрлөг боловсруулалтын ул мөр /Metallurgical site/. Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн олдворлож байсан уурхай болон түүнийг боловсруулж байсныг гэрчлэх ул мөр бүхий дурсгалт газрууд хамаарна.	
44	Шавар боловсруулалтын ул мөр /Clay-production site/. Тодорхой түүхэн цаг үед хүмүүс шавар ахуйн хэрэгцээний сав суулга, барилгын хэрэглэгдэхүүн зэрэг эд зүйлс	

	хийж байсан болон хийсэн зүйлсээ шатаан боловсруулж байсан ул мөр бүхий дурсгалт газрууд хамаарна.	
45	Газар тариалангийн ул мөр /Agricultural site/. Түүхэн тодорхой цаг үед хүмүүс газар хагалж, суваг шуудуу татах зэргээр тариалан эрхэлж байсныг гэрчлэх ул мөр бүхий газар нутаг хамаарна.	
46	Чулуу олдворлолтын ул мөр /Stone quarry/. Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн олдворлож байсан чулуу эсвэл томоохон хад асга хагалж түүнийг боловсруулан ашиглаж байсныг гэрчлэх ул мөр бүхий дурсгалт газрууд хамаарна.	
47	Бусад /Other/.	
48	Кембрийн өмнөх цаг үе буюу архей протерозойн эриний олдворт газрууд /archeanAndProterozoiLocalitiesOfPre-CambrianPeriod/. Кембрийн өмнөх цаг үеийн судалгаа буюу бактерийн палеонтологийн судалгаатай холбоотой олдворт газрууд /2500-540 сая жилийн өмнөх/.	<p align="center">Палеонтологийн дурсгалт газрын ангилал /paleontologicalSiteTypeValue/</p>
49	Палеозойн эриний амьтан ургамлын олдворт газрууд /PaleozoicLocalities/. Палеозойн эриний амьтан ургамлын судалгаа буюу эртний далай сав газрын амьтан ургамлын судалгааны олдворт газрууд юм /540-250 сая жилийн өмнөх/.	
50	Мезозойн эриний амьтан ургамлын олдворт газрууд /MesozoicLocalities/. Мезозойн эриний амьтан ургамлын судалгаа буюу эртний эх газрын ноёлогч бүлгүүдийн гол цөм олдож судлагдаж байгаа олдворт газрууд /250-65 сая жилийн өмнөх/.	
51	Кайнозойн эриний амьтан ургамлын дурсгалт газрууд /CenozoicLocalities/. Кайнозойн эриний амьтан ургамлын судалгаа буюу эртний хөхтөн амьтад /сүүн тэжээлтэн/-ын олдворт газрууд /65-1,8 сая жилийн өмнөх/.	

В.1.3 Үл хөдлөх дурсгалын анхдагч ангилал– Immovable monument primary type value

Д/д	Анхдагч ангилал	Дэд ангилал	Үндсэн ангилал
1	Түрэг /turkic/	<p align="center">Тамга, тэмдэг, бичгийн дурсгал /stampsSymbolsAndInscriptionMonument/</p>	<p align="center">Хадны зураг, бичгийн дурсгалын ангилал /rockArtAndInscriptionTypeValue/</p>
2	Уйгур /uyghur/		
3	Кидан /kidan/		
4	Монгол /mongolian/		

5	Тод /vivid/		
6	Дөрвөлжин /slab/		
7	Манж /manchu/		
8	Согд /sogd/		
9	Араб /arabian/		
10	Перс /persian/		
11	Санскрит /sanskrit/		
12	Төвд /tibetan/		
13	Хятад /china/		
14	Бусад /other/		
15	Зэл чулуу /Балбал /zel stone/	Тахилын онгон /sacrificialSite/	Тахил тайлгын байгууламжийн ангилал /sacrificialSiteTypeValue/
16	Хашлага чулуу /palisade stone/		
17	Хүннү /xiongnu/	Эртний хот /ancientSettlement/city/	Барилга, архитектурын дурсгалын ангилал /architecturalAndBuildingSiteTypeValue/
18	Түрэг /turkic/		
19	Уйгур /uyghur/		
20	Кидан /kidan/		
21	Монгол /mongolian/		
22	Манж /manchu/		
23	Тодорхойгүй /unknown/		
24	Уран барилга /Architectural building/	Архитектурын дурсгал /architecturalMonument/	
25	Уран барилгын цогцолбор /architectural complex/		
26	Temple (Сүм, хийд)		
27	Уран баримал, хөшөө /sculpture, statue/		
28	Сүрлэг чимэглэлийн дүрслэл /a majestic decoration portrayal/		
29	Хүрэл /bronze/	Хүн чулуу /humanStone/	Хөшөө дурсгалын ангилал /monumentTypeValue/
30	Түрэг /turkic/		

31	Уйгур /uyghur/		
32	Кидан /kidan/		
33	Монгол /mongolian/		
34	Тодорхойгүй /unknown/		
35	Стратиграфийн тулгуур зүсэлт газрууд /localitiesOfGeologicalTypeSection/	Кембрийн өмнөх цаг үе буюу архей протерозойн эриний олдворт газрууд /archeanAndProterozoiLocalitiesOfPre-CambrianPeriod/	Палеонтологийн дурсгалт газрын ангилал /paleontologicalSiteTypeValue/
36	Урьд кембрийн амьтны олдворт газрууд /pre-CambrianLocalities/		
37	Мөр хөлтөн /trilobite/	Палеозойн эриний амьтан ургамлын олдворт газрууд /paleozoicLocalities/	
38	Далайн шүр /coral/	Далай тэнгисийн амьтны олдворт газруудын ангилал /classificationOfMarineDepositedLocalities/	
39	Ургамлын дардас /fossilPlant/	Мезозойн эриний амьтан ургамлын олдворт газрууд /mesozoicLocalities/	
40	Чулуужсан мод /petrifiedWood/	Нуур усны амьтан ургамлын олдворт газруудын ангилал /classificationOfLacustrineDepositedLocalities/	
41	Эртний загас /fossilFish/		
42	Дун хясаа /bivalve/		
43	Үлэг гүрвэл /dinosaur/	Мезозойн эриний амьтан ургамлын олдворт газрууд /mesozoicLocalities/	
44	Үлэг гүрвэлийн өндөг /dinosaurEggs/	Эх газрын амьтан ургамлын олдворт газруудын ангилал /classificationOfTerrestrialLocalities/	
45	Эртний хөхтөн амьтдын олдворт газрууд /localitiesOfFossilMammals/	Кайнозойн эриний амьтан ургамлын дурсгалт газрууд	
46	Хөхтөн /extantMammals/	/cenozoicLocalities/	

B.1.4 Үл хөдлөх дурсгалын чулуулгийн төрөл, ангилал – Solid type value

Д/д	Ангиллын утга	Тодорхойлолт
1	Боржин /granite/	Боржин.
2	Гантиг /marble/	Гантиг.
3	Занар /shale/	Занар (билүүний чулуу, шаварлаг).
4	Элсэн чулуу /sandstone/	Элсэн чулуу.

5	Хүрмэн чулуу /trap/	Хүрмэн чулуу.
6	Цахиурлаг чулуу /siliceousStone/	Цахиурлаг чулуу.
7	Бөсөл /tufa/	Бөсөл (Улаан, шаргал өнгөтэй).
8	Шохойн чулуу /limestone/	Шохойн чулуу.
9	Өөхөн чулуу /soapstone/	Өөхөн чулуу.
10	Бусад /other/	Бусад.

В.1.5 Хүний үйл ажиллагаагаар учирсан гэмтлийн төрөл, ангилал – Anthropogenic damage type value

Д/д	Ангиллын утга	Тодорхойлолт
1	Тоносон /despoiled/	Тоносон.
2	Сүйтгэсэн /destroyed/	Сүйтгэсэн.
3	Будаж балласан /paintedAndBlackout/	Будаж балласан.
4	Хугалсан /refractive/	Хугалсан.
5	Сийлсэн /glyphic/	Сийлсэн.
6	Зөөгдсөн /moved/	Зөөгдсөн.
7	Алга болсон /disappearance/	Алга болсон.
8	Тос, сүүний бохирдолттой /milkAndButterPollution/	Тос, сүүний бохирдолттой.
9	Буруу зассан /misRepaired/	Буруу зассан.
10	Хадаг, бөс даавуу ороосон, уясан /khadagAndClothTied/	Хадаг, бөс даавуу ороосон, уясан.
11	Дэд бүтцийн аюулд өртсөн /infrastructureEndanger/	Дэд бүтцийн аюулд өртсөн.
12	Аж ахуйн үйл ажиллагаанд өртсөн /economicActivityReached/	Аж ахуйн үйл ажиллагаанд өртсөн.

В.1.6 Байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр учирсан гэмтлийн төрөл, ангилал – Natural damage type value

Д/д	Ангиллын утга	Тодорхойлолт
-----	---------------	--------------

1	Нарны нөлөөлөл /sunImpact/	Нарны нөлөөлөл.
2	Салхины нөлөөлөл /windImpact/	Салхины нөлөөлөл.
3	Эрдэс шохойн нөлөөлөл /mineralAndLimeImpact/	Эрдэс шохойн нөлөөлөл.
4	Үер, усны нөлөөлөл /floodAndWaterImpact/	Үер, усны нөлөөлөл.
5	Аянга, цахилгаанд өртсөн /thunderAndLightningImpact/	Аянга, цахилгаанд өртсөн.
6	Гал түймэрт өртсөн /fireImpact/	Гал түймэрт өртсөн.
7	Газар хөдлөлт /earthquake/	Газар хөдлөлт.
8	Хаг, ургамлын нөлөө /lichenAndPlantImpact/	Хаг, ургамлын нөлөө.
9	Биологийн бохирдолттой /biologicalPollution/	Биологийн бохирдолттой (сангас) /bird's excrement/.
10	Чулууны өгөршил /stoneDisrepair/	Чулууны өгөршил.
11	Мал, амьтны нөлөөлөл /livestockAndAnimalImpact/	Мал, амьтны нөлөөлөл.

В.1.7 Хүрээний төрөл, ангилал – Zone type value

Д/д	Ангиллын утга	Тодорхойлолт
1	Хамрах хүрээ /monumentZone/	Дурсгалын хамрах хүрээ.
2	Хамгаалалтын хүрээ /protectionZone/	Дурсгалын хамгаалалтын хүрээ.

В.1.8 Хамгаалалтын төрөл, ангилал – Protection type value

Д/д	Ангиллын утга	Тодорхойлолт
1	Улсын хамгаалалтад /nationalProtection/	Улсын хамгаалалтад.
2	Аймгийн хамгаалалтад /provinceProtection/	Аймгийн хамгаалалтад.
3	Сумын хамгаалалтад /soumProtection/	Сумын хамгаалалтад.
4	Хамгаалалтад аваагүй /noProtection/	Хамгаалалтад аваагүй.


В.1.9 Хамгаалалтын зэрэглэл өөрчлөх саналын ангилал – Protection change proposal

Д/д	Ангиллын утга	Тодорхойлолт
1	Улсын хамгаалалтаас аймгийн хамгаалалтад /fromNationalToProvince/	Улсын хамгаалалтаас аймгийн хамгаалалтад.
2	Аймгийн хамгаалалтаас улсын хамгаалалтад /fromProvinceToNational/	Аймгийн хамгаалалтаас улсын хамгаалалтад.
3	Сумын хамгаалалтаас аймгийн хамгаалалтад /fromSoumToProvince/	Сумын хамгаалалтаас аймгийн хамгаалалтад.
4	Аймгийн хамгаалалтаас сумын хамгаалалтад /fromProvinceToSoum/	Аймгийн хамгаалалтаас сумын хамгаалалтад.
5	Саналгүй /NoProposal/	Саналгүй.


С Хавсралт
(норматив)

UML (Загварчлалын нэгдмэл хэл)-ийн диаграмм


С.1 Өгөгдлийн багц - Түүх, соёлын үл хөдлөх дурсгал өгөгдөл (Immovable historical and cultural monuments)




С.1-р зураг - UML диаграмм: Бусад дэд өгөгдлийн сантай холбогдсон байдал



С.2-р зураг - UML диаграмм: “Түүх, соёлын үл хөдлөх дурсгал”-ын хэрэглээний тойм схем



С.3-р зураг - UML диаграмм: “Түүх, соёлын үл хөдлөх дурсгал”-ын биет төрлийн схем



С.4-р зураг - UML диаграмм: “Түүх, соёлын үл хөдлөх дурсгал”-ын кодын жагсаалтын схем

D Хавсралт
(норматив)

Өгөгдлийн чанар

D.1-р хүснэгт - Түүх, соёл, археологийн өв орон зайн өгөгдлийг үнэлэх чанарын элементүүд

Хэсэг	Өгөгдлийн чанарын элемент	Өгөгдлийн чанарын дэд элемент	Тодорхойлолт	Үнэлгээний хамрах хүрээ
1	Иж бүрдэл	Илүүдэл	Өгөгдлийн сангийн хамрах хүрээнд дурдсанаас илүүц өгөгдөл	өгөгдлийн багц
2	Иж бүрдэл	Гээгдэл	Хамрах хүрээгээр тодорхойлсон өгөгдлийн сангаас гээгдсэн өгөгдөл	өгөгдлийн багц
3	Утга агуулгын нийцтэй байдал	Ойлголтын нийцтэй байдал	Ойлголтын схемийн дүрмийг дагаж мөрдөх	орон зайн объектын төрөл /орон зайн объект
4	Утга агуулгын нийцтэй байдал	Домэйний нийцтэй байдал	Домэйн утгыг дагаж мөрдөх	орон зайн объектын төрөл /орон зайн объект
5	Байршлын нарийвчлал	Абсолют эсвэл гадаад нарийвчлал	Мэдээлэгдсэн координатын утгууд нь хүлээн зөвшөөрөгдсөн эсвэл үнэн байх утгатай ойролцоо байна	өгөгдлийн багц
6	Сэдэвчилсэн нарийвчлал	Атрибутын тоон бус шинж чанартай тохирох	Атрибутын тоон бус шинж чанартай тохирох байдал	орон зайн объектын төрөл

D.1.1-р хүснэгт – Иж бүрдэл – Илүүдэл

Бүрэлдэхүүн хэсэг	Дүрслэл
Нэр	Илүүдэл зүйл
Хоёр дахь нэр	-
Элементийн үзүүлэлт	Илүүдэл
Элементийн дэд үзүүлэлт	Алдаа заагч
Өгөгдлийн чанарын үндсэн хэмжүүр	Өгөгдөлд алдаатай дүрслэгдсэн зүйлийг заах
Тодорхойлолт	Өгөгдлийн багц доторх илүүдэл зүйл

Тайлбар	-
Үнэлгээний цар хүрээ	Өгөгдлийн багц
Тайлан, хамрах хүрээ	Өгөгдлийн багц
Параметр	-
Элементийн төрөл	Бодит, хувь, харьцаа (жиш: 0,0189 ; 98,11% ; 11:582)
Элементийн бүтэц	-
Эх сурвалж	Түүх, соёл, археологийн үл хөдлөх дурсгалуудыг агуулсан өгөгдлийн сан
Жишээ	Өгөгдлийн багцад давхардсан дурсгалуудын тоо
Тодорхойлогч хэмжүүр	3

D.1.2-р хүснэгт – Иж бүрдэл – Гээгдэл

Бүрэлдэхүүн хэсэг	Дүрслэл
Нэр	Гээгдсэн зүйл
Хоёр дахь нэр	-
Элементийн үзүүлэлт	Гээгдэл
Элементийн дэд үзүүлэлт	Алдаа заагч
Өгөгдлийн чанарын үндсэн хэмжүүр	Өгөгдөлд гээгдсэн зүйлийг заах
Тодорхойлолт	Өгөгдлийн сангаас гээгдсэн, орхигдсон зүйл
Тайлбар	-
Үнэлгээний цар хүрээ	Өгөгдлийн багц
Тайлан хамрах хүрээ	Өгөгдлийн багц
Параметр	-
Элементийн төрөл	Бодит, хувь, харьцаа (жиш: 0,0189 ; 98,11% ; 11:582)
Элементийн бүтэц	-
Эх сурвалж лавлагаа	Түүх, соёл, археологийн үл хөдлөх дурсгалуудыг агуулсан өгөгдлийн сан
Жишээ	Ямар ч бүртгэлгүй гээгдсэн дурсгалууд
Тодорхойлогч хэмжүүр	7

D.1.3 - Утга агуулгын нийцтэй байдал – Ойлголтын нийцтэй байдал

Бүрэлдэхүүн хэсэг	Дүрслэл
Нэр	
Хоёр дахь нэр	-
Элементийн үзүүлэлт	Утга агуулгын нийцтэй байдал
Элементийн дэд үзүүлэлт	Ойлголтын нийцтэй байдал
Өгөгдлийн чанарын үндсэн хэмжүүр	Алдаа заагч

Тодорхойлолт	Ойлголтын схемийн дүрэмтэй нийцэхгүй өгөгдлийн багцад байгаа бүх зүйлийг тоолох
Тайлбар	Хэрэв ойлголтын схем ил эсвэл далд хэлбэрийн дүрмийг тодорхойлсон бол дараах хэсгийг дагаж мөрдөнө. Жишээ нь: Биетийн буруу байршуулалт, биетийн давхардалт, давхцал.
Үнэлгээний цар хүрээ	Орон зайн объект / орон зайн объектын төрөл
Тайлан хамрах хүрээ	Өгөгдлийн багц
Параметр	-
Элементийн төрөл	Бүхэл тоо
Элементийн бүтэц	-
Эх сурвалж лавлагаа	ISO/DIS 19157 Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанар
Жишээ	-
Тодорхойлогч хэмжүүр	10

D.1.4 - Утга агуулгын нийцтэй байдал – Домэйн утгын үл нийцэл

Бүрэлдэхүүн хэсэг	Дүрслэл
Нэр	Домэйн утгын үл нийцэл
Хоёр дахь нэр	-
Элементийн үзүүлэлт	Утга агуулгын нийцтэй байдал
Элементийн дэд үзүүлэлт	
Өгөгдлийн чанарын үндсэн хэмжүүр	Алдаа заагч
Тодорхойлолт	Зүйл нь домэйн утгатай нийцэхгүй байгааг заах
Тайлбар	
Үнэлгээний цар хүрээ	Орон зайн объект / орон зайн объектын төрөл
Тайлан хамрах хүрээ	Өгөгдлийн багц
Параметр	-
Элементийн төрөл	Бүхэл тоо
Элементийн бүтэц	-
Эх сурвалж лавлагаа	ISO/DIS 19157 Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанар
Жишээ	-
Тодорхойлогч хэмжүүр	

D.1.5 - Байрлалын нарийвчлал – Абсолют буюу гадаад нарийвчлал

Бүрэлдэхүүн хэсэг	Дүрслэл
Нэр	Байршлын тодорхойгүй байдлын дундаж утга
Хоёр дахь нэр	Байршлын тодорхойгүй байдлын дундаж утга (1D, 2D болон 3D)
Элементийн үзүүлэлт	Байршлын нарийвчлал
Элементийн дэд үзүүлэлт	Абсолют буюу гадаад нарийвчлал

Өгөгдлийн чанарын үндсэн хэмжүүр	Ашиглах боломжгүй
Тодорхойлолт	Байрлалын тодорхойгүй байдлыг тогтооход зориулсан тодорхойгүй байршлын дундаж утга нь хэмжсэн байршил ба байвал зохих бодит байршил хоорондын зайгаар тодорхойлогдоно.
Тайлбар	<p>Цэгүүдийн байрлал нь хэмжигдсэн, цэгүүдийн тоо (N) хэмжсэн байрлал нь X_{mi}, ба Y_{mi}, координат хэмжээстээс хамаарсан хэлбэрээр тодорхойлогдоно. X_{ii}, ба Y_{ii} -ийн харьцаатай координатууд нь жинхэнэ байрлалыг илэрхийлнэ. Алдааг дараах байдлаар тооцоолно.</p> $1D: e_i = x_{mi} - x_{ii} $ $2D: e_i = \sqrt{(x_{mi} - x_{ii})^2 + (y_{mi} - y_{ii})^2}$ <p>Хэвтээ шугамын эсвэл гадаад байрлалын тодорхойгүй байдлын дунджийг дараах байдлаар тодорхойлно.</p> $\bar{e} = \frac{1}{N} \sum_{i=1}^N e_i$ <p>Нийлэмжтэй харилцааг тогтоох шалгуурыг бас дурдах ёстой (жишээлбэл хамгийн ойр байрлалд нийлэмжтэй). Өгөгдлийн чанарын үнэлгээний үр дүнг харгалзах оноог олох шалгуур / нөхцөлийг илэрхийлнэ. Энэ өгөгдлийн чанарын хэмжүүр нь стандарт хазайлтаас ялгаатай.</p>
Үнэлгээний цар хүрээ	Өгөгдлийн багц
Тайлан хамрах хүрээ	Өгөгдлийн багц
Параметр	-
Элементийн төрөл	Хэмжих нэгж
Элементийн бүтэц	Дан утга, багц, дараалал, хүснэгт, матриц эсвэл бүрхэц
Эх сурвалж лавлагаа	ISO/DIS 19157 Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанар
Жишээ	
Тодорхойлогч хэмжүүр	28 (ISO 19157)

D.1.6 - Сэдэвчилсэн нарийвчлал - Атрибутын тоон бус шинж чанартай тохирох

Бүрэлдэхүүн хэсэг	Дүрслэл
Нэр	Атрибутын алдаагүй утгын түвшин
Хоёр дахь нэр	-
Элементийн үзүүлэлт	Сэдэвчилсэн нарийвчлал
Элементийн дэд үзүүлэлт	Атрибутын тоон бус шинж чанартай тохирох
Өгөгдлийн чанарын үндсэн хэмжүүр	Алдаагүй зүйлсийн үзүүлэлт
Тодорхойлолт	Атрибутын утгын нийт тоотой холбоотой атрибутын утгын алдаагүй тоо
Тайлбар	-
Үнэлгээний цар хүрээ	Орон зайн объект / орон зайн объектын төрөл
Тайлан хамрах хүрээ	Өгөгдлийн багц

Параметр	-
Элементийн төрөл	Бодит, хувь, харьцаа (жиш: 0,0189 ; 98,11% ; 11:582)
Элементийн бүтэц	Дан утга, багц, дараалал, хүснэгт, матриц эсвэл бүрхэц
Эх сурвалж лавлагаа	ISO/DIS 19157 Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанар
Жишээ	0.0189 ; 98.11% ; 11:582
Тодорхойлогч хэмжүүр	67 (ISO 19157)

ТӨСӨӨГ

НОМ ЗҮЙ

- [1] INSPIRE DS-D2.5, Ерөнхий ойлголтын загвар, хувилбар 3.4
- [2] INSPIRE DS-D2.8.I.3:2014, Газар зүйн нэрийн өгөгдлийн үзүүлэлт-Техникийн шаардлага
- [3] INSPIRE DS-D2.8.III.8, Үйлдвэрийн байгууламжийн өргөтгөл болон өгөгдлийн үзүүлэлт
- [4] INSPIRE DS-D2.8.I.4, Засаг захиргааны нэгж өгөгдлийн үзүүлэлт
- [5] ISO/TS 19103:2005, Газар зүйн мэдээлэл – Ойлголтын схемийн хэл
- [6] ISO/DIS 19157, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанар
- [7] MNS 1-1:2006, Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт
- [8] MNS 1-2:2006, Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт
- [9] MNS ISO/TS 19104:2012 Газар зүйн мэдээлэл - Нэр томъёо
- [10] MNS 5774:2007 Газар зүйн мэдээлэл – Мета өгөгдөл
- [11] Газрын тухай хууль
- [12] Соёлын өвийг хамгаалах тухай хууль
- [13] Монголын түүхийн тайлбар толь
- [14] Г.Энхбат, Ж.Батсуурь “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалд сөрөг нөлөөт хүчин зүйлсийн учруулах эрсдэлийн үнэлгээний судалгаа”, Улаанбаатар хот, 2020 он